



МОНГОЛ УЛСЫН
ЗАМ, ТЭЭВРИЙН САЙДЫН
ТУШААЛ

2012 оны 10 сарын 16 өдөр

Дугаар 12

Улаанбаатар хот

«Авто зам, гүүрийн барилга байгууламжийг ашиглалтанд оруулах техникийн комиссын бүрэлдэхүүнийг томилох тухай

Монгол Улсын “Засгийн газрын тухай” хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь заалт, Засгийн газрын 2009 оны 72 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Зам, тээврийн яамны захиалгаар хэрэгжиж байгаа дараах авто зам, замын байгууламжийг ашиглалтад оруулах техникийн комиссыг удирдан зохион байгуулж ажиллахыг Зам, тээврийн хяналт, бүртгэлийн газар /Б.Жаргал/-т хариуцуулсугай.

1/ Засгийн газар хоорондын хэлэлцээрийн дагуу гадаад, дотоодын хөрөнгө оруулалттай, улсын болон олон улсын шинж чанартай авто зам, замын байгууламж;

2/ Хөрөнгийн эх үүсвэр харгалзахгүйгээр үйлчлэх хүрээ нь улсын болон бүс нутгийн чанартай, технологийн нарийн горим бүхий авто зам, замын байгууламж;

3/ Ээлжит болон их засвар, шинэчлэлт хийгдсэн авто зам, замын байгууламжууд;

2. Техникийн комиссын бүрэлдэхүүнийг “Барилга байгууламжийг ашиглалтад оруулах дүрэм”-ийн дагуу тухай бүр томилуулж ажиллуулахыг Зам, тээврийн хяналт, бүртгэлийн газрын дарга Б.Жаргалд даалгасугай.

3. Энэ тушаалын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Төрийн нарийн бичгийн дарга /Б.Батзаяа/ -д үүрэг болгосугай.



А. ГАНСҮХ

08 000120